



МОНГОЛ
УЛСЫН
ХУУЛЬ
12 дугаар сарын 11
№46 /619/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

000

МОНГОЛ УЛСЫН
ЦЭРГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

011

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД
ЦЭРГИЙН ТОГТООЛ

026

Улаанбаатар хот
2009 он

**Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай
хуульд нэмэлт оруулах тухай**

**Хохирогчид нөхөх олговор олгох
журам батлах тухай**

**Иргэний цэргийн үүргийн болон
цэргийн албан хаагчийн эрх
зүйн байдлын тухай хууль,
Цэргийн албан хаагчийн тэтгэвэр,
тэтгэмжийн тухай хуулийн зарим
зүйл, заалтыг тайлбарлах тухай**

Улсын Их Хурлын Тамгын Газар

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | | |
|------|--|--|------|
| 599. | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 1000 |
|------|--|--|------|

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|------|
| 600. | Хуулийн төслүүд буцаах тухай | Дугаар 76 | 1000 |
| 601. | Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай | Дугаар 77 | 1001 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|------------|------|
| 602. | Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай | Дугаар 284 | 1001 |
| 603. | Журамд нэмэлт оруулах тухай | Дугаар 285 | 1003 |
| 604. | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай | Дугаар 286 | 1006 |
| 605. | Журам батлах тухай | Дугаар 287 | 1007 |
| 606. | Жагсаалтад нэмэлт оруулах тухай | Дугаар 288 | 1009 |
| 607. | Зээлийн хөрөнгийн хуваарилалтын тухай | Дугаар 289 | 1010 |
| 608. | Хохирогчид нөхөх олговор олгох журам батлах тухай | Дугаар 294 | 1011 |
| 609. | Эрчим хүчний салбарын 2009-2010 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 295 | 1016 |
| 610. | Мал өвөлжилтийн бэлтгэл хангахтай холбогдуудан авах нэмэлт арга хэмжээний тухай | Дугаар 296 | 1020 |

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|--|------|
| 611. | Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай | | 1026 |
|------|---|--|------|



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 11 дүгээр
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 8 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 8.9 дэх хэсэг нэмсүгэй:

“8.9.Эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй эмийг гамшгийн болон онцгой нөхцөл байдал үүссэн үед зайлшгүй шаардлагаар гадаадаас авах тохиолдолд энэ хуулийн 5.2-т заасан салбар зөвлөлийн саналыг үндэслэн эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр импортлох зөвшөөрөл олгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2009 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 11 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар 76

Улаанбаатар
хот

Хуулийн төслүүд буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Засгийн газраас 2009 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 11 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар
хот

Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн алдагдал болон санхүү, эдийн засгийн хямралыг даван туулах зарим арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулан 250 тэрбум төгрөг хүртэлх үнэт цаас гаргаж арилжаалахыг Засгийн газар /С.Батболд/-т зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолыг 2009 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 284

Улаанбаатар
хот

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд С.Баярцогт, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай:

а) эрчим хүчний салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын гадаадын урт хугацаат зээлийн үндсэн өр болон зээлийн хүүгийн төлбөр төлөлтийн хугацааг 3 жилээр хойшлуулах асуудлыг судалж зохих журмын дагуу шийдвэрлэх;

б) түлш, эрчим хүчний салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын үйлдвэрлэл, техникийн найдвартай ажиллагааг хангах, эдийн засгийн үзүүлэлтийг сайжруулах зорилгоор тэдгээрийн гүйцэтгэх захиралтай төлөөлөн удирдах зөвлөлөөс байгуулах

гэрээний нөхцөл, ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулан баталж мөрдүүлэх;

в) Монгол Улсыг хөгжүүлэх сан болон улсын төсвийн санхүүжилтээр хөрөнгө оруулалт хийсэнтэй холбогдуулан түлш, эрчим хүчний компаниудын хоорондын өр, авлагыг бууруулах зохицуулалтын арга хэмжээ авах;

г) төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой түлш, эрчим хүчний компаниудын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь сайжруулах чиглэлээр гадаад, дотоодын нэр хүнд бүхий компани, менежментийн багтай гэрээ байгуулах боломжийг судлан тодорхой санал боловсруулж танилцуулах.

2. Азийн хөгжлийн банкны урт хугацааны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Дулааны үр ашиг” төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн зарим хэсгийг эзэмшиж байгаа Улаанбаатар хотын Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газрын харьяа орон сууц, нийтийн аж ахуйн компаниудтай шинээр гэрээ байгуулж, уг зээлийг төлүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр нарт даалгасугай.

3. Мэдээлэл, харилцаа холбооны салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төслийн дамжуулан зээлдүүлэх зээлийн хүүг бууруулах, эдгээр зээлийн төлбөрийг нэгдсэн нэг валютаар тооцох талаар холбогдох гэрээнд өөрчлөлт оруулах асуудлыг 2009 онд багтаан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар (Ж Сансар), Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

4. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор зүү, тариур гадаадаас импортлохыг хязгаарлах, зүү тариурын үйлдвэрлэлд хэрэглэх тоног төхөөрөмж, түүхий эд, материалыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх талаар санал боловсруулж танилцуулахыг Сангийн сайд С.Баярцогт, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа нарт даалгасугай.

5. Харилцаа холбооны салбарт гадаадын урт хугацааны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн зарим хэсгийг эзэмшиж байгаа “Монголын цахилгаан холбоо” ХК-тай шинээр гэрээ байгуулж, уг зээлийг төлүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

6. Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкны урт хугацааны

зээлийн санхүүжилтээр зам засвар, арчлалтын компаниудад хэрэгжүүлсэн тээвэр хөгжүүлэх төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн хэмжээгээр эдгээр компаниудын дүрмийн санг нэмэгдүүлэх асуудлыг 2009 онд багтаан зохих журмын дагуу шийдвэрлэхийг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД**

Д.ЗОРИГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 285

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт оруулах тухай

Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2006 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 160 дугаар тогтоолоор баталсан "Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам"-д дор дурдсан агуулга бүхий Дөрөв дэх хэсэг нэмсүгэй:

"Дөрөв. Үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг дүгнэх, мэдээлэх

17. Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага нь Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор баталсан Үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн удирдлага, зохицуулалт болон үр дүн, биелэлтэд нь хяналт тавьж, явц, дүнд хяналт шинжилгээ хийж, хэрэгжилтийн үр дүн, мэдээг энэхүү журмын 5, 6, 7 дугаар хавсралт ёсоор гарган, хагас жилийн дүнг 8 дугаар сарын 20-ны дотор, бүтэн жилийн дүнг дараа оны 4 дүгээр сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлнэ.

18. Сангийн яам төсвийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийг нэгтгэн хагас жилийн дүнг 7 дугаар сарын 20-ны дотор, жилийн эцсийн дүнг дараа оны 3 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлнэ.



19. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Үндэсний хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийн талаар төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, Сангийн яамнаас ирүүлсэн дүн, мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн, хяналт шинжилгээ хийж, жил бүрийн 5, 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

20. Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага нь Үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн байдал, үр дүн, явцын талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх жилийн эцсийн дүнг дэлгэрэнгүй тайлантай хамт ирүүлнэ”.

2. “Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам”-ын 5, 6, 7 дугаар хавсралтуудыг хавсралт ёсоор баталсугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгорт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

М.ЭНХБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Б.ДОЛГОР

**Засгийн газрын 2009 оны 285 дугаар
тогтоолын хавсралт**

“Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам”-ын 5 дугаар хавсралт

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

(200... оны эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр, төслийн нэр, батлагдсан огноо, шийдвэрийн дугаар	Биелүүлэх хугацаа	Хяналтад авсан заалт	Хэрэгжилтийн явц	
				Тухайн жилд хийсэн ажлын явц (хувь)	Хөтөлбөр, төсөл хэрэгжсэнээс хойш хийсэн ажлын явц (хувь)
А	1	2	3	4	5
	Нэг. Үндэсний хөтөлбөр				
	Нийт				
	Хоёр.Төсөл				
	Нийт				

**Гарын үсэг (тэмдэг)**

Тайлбар: "Гарын үсэг (тэмдэг)" гэсэн хэсэгт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарсан байна.

"Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам"-ын 6 дугаар хавсралт

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖИЛЛАГААНД ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛСАН ТОВЧ ДҮН

(200... оны эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар)

№	Үзүүлэлт	Үүнээс							
		Хөтөлбөр				Төсөл			
	Хөтөлбөр, төслийн нэр	Нийт зарцуулах хөрөнгө	Тухайн жилд төсөвлөсөн хөрөнгө	Тухайн жилд зарцуулсан хөрөнгө	Хөтөлбөр хэрэгжсэнээс хойш зарцуулсан хөрөнгө	Нийт зарцуулах хөрөнгө	Тухайн жилд төсөвлөсөн хөрөнгө	Тухайн жилд зарцуулсан хөрөнгө	Төсөл хэрэгжсэнээс хойш зарцуулсан хөрөнгө
А	1	2	3	4	5	6	7	8	9
	Нийт								

Гарын үсэг (тэмдэг)

Тайлбар: "Гарын үсэг (тэмдэг)" гэсэн хэсэгт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарсан байна.

"Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам"-ын 7 дугаар хавсралт

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ НЬ УДААШИРСАН БОЛОН ТАСАРЧ БАЙГАА ЗААЛТЫН ЖАГСААЛТ

(200... оны эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр, төслийн товч утга, батлагдсан огноо, шийдвэрийн дугаар	Заалтын агуулга	Шалтгаан (Тасарсан болон удааширч байгаа шалтгааныг тодорхой бичнэ)
А	1	2	3
	Нэг. Хөтөлбөр		
	Нийт		



Хоёр. Төсөл		
Нийт		

Гарын үсэг (тэмдэг)

Тайлбар: "Гарын үсэг (тэмдэг)" гэсэн хэсэгт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарсан байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 286

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "2009 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай" Засгийн газрын 2009 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан хүснэгтийн "салбар" гэсэн хэсгийн "В", "F" заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

В				Уул уурхай, олборлолт																
	06			Түүхий газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлолт	65	75	80	80	80	80	80	80	80	80	80	80	80	80	80	80
	09	099	0990	Уул уурхайн хайгуул, олборлолт, бусад туслах үйл ажиллагаа	25	25	25	25	25	25	25	25	25	25	25	25	25	25	25	25

F				Барилга Барилга угсралт																
	41	410	4100		20	25	30	25	30	35	30	35	40	35	40	45				



	421	4210	Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа	20	25	30	25	30	35	30	35	40	35	40	45
			Уул уурхайн барилга угсралт	20	25	30	25	30	35	30	35	40	40	40	40

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД**М.ЭНХБОЛД****НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД****Т.ГАНДИ****МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2009 оны 9 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 287

Улаанбаатар
хот**Журам батлах тухай**

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Уул уурхай, дэд бүтцийн салбарт алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх аргачлал, зааварт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулж батлан мөрдүүлэхийг Татварын ерөнхий газар (Ц.Оюунбаатар)-т даалгасугай.

3. Энэ тогтоолыг 2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД**М.ЭНХБОЛД****САНГИЙН САЙД****С.БАЯРЦОГТ****Засгийн газрын 2009 оны 287 дугаар
тогтоолын хавсралт****УУЛ УУРХАЙ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРТ АЛДАГДЛЫГ
ИРЭЭДҮЙД ШИЛЖҮҮЛЭН ТООЦОХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Уул уурхай, дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцоход энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж гэдэгт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж, ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг хэлнэ.

1.3. Дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж гэдэгт төмөр замын суурь дэд бүтэц, авто зам, замын байгууламж барих, эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг хэлнэ.

Хоёр. Татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацаа

2.1. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн татварын тайлангаар гарсан алдагдлыг тухайн аж ахуйн нэгжийн тайлант жил, түүний өмнөх дараалсан 3 хүртэлх жилийн хугацаанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг үндэслэн дараахь хугацаагаар ирээдүйд шилжүүлэн тооцож болно:

№	Хөрөнгө оруулалтын хэмжээ (тэрбум төгрөг)	Алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацаа
1	0-300.0 хүртэл	4 жил
2	300.0-500.0 хүртэл	5 жил
3	500.0-700.0 хүртэл	6 жил
4	700.0-1000.0 хүртэл	7 жил
5	1000.0 буюу түүнээс дээш	8 жил

2.2. Дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн татварын тайлангаар гарсан алдагдлыг тухайн аж ахуйн нэгжийн тайлант жил, түүний өмнөх дараалсан 3 хүртэлх жилийн хугацаанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг үндэслэн дараахь хугацаагаар ирээдүйд шилжүүлэн тооцож болно:

№	Хөрөнгө оруулалтын хэмжээ (тэрбум төгрөг)	Алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацаа
1	0-100.0 хүртэл	4 жил
2	100.0-200.0 хүртэл	5 жил
3	200.0-300.0 хүртэл	6 жил
4	300.0-500.0 хүртэл	7 жил
5	500.0 буюу түүнээс дээш	8 жил

2.3. Уул уурхай, дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж нь эдийн засгийн бусад салбарт үйл ажиллагаа давхар эрхэлдэг бол тус аж ахуйн нэгжийн татварын тайлангаар гарсан



алдагдлын зөвхөн уул уурхай, дэд бүтцийн салбарын үйл ажиллагаанд ногдох хэсгийг энэхүү журмын дагуу ирээдүйд шилжүүлэн тооцно.

2.4. Өмнөх жилүүдийн алдагдал шилжиж дуусаагүй үед дахин алдагдал үүссэн бол уг шилжээгүй алдагдлыг энэхүү журмын 2.1, 2.2-т заасан хугацаанд багтаан шилжүүлэн тооцно. Энэхүү журмын 2.1, 2.2-т заасан хугацаанаас хэтэрсэн алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцохгүй.

2.5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу тайлант жилд гарсан алдагдлыг шилжүүлэх хугацааг тоолохдоо дараагийн жилүүдийн үйл ажиллагааны үр дүнгээс үл хамааран алдагдалтай жилүүдийг оруулж тооцно.

2.6. Алдагдлыг ирээдүйд шилжүүлэхдээ эхэлж гарсан алдагдлыг эхэнд нь шилжүүлэх зарчим баримтална.

2.7. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газарт тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгжтэй байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээнд алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацааг 4-8 жил байхаар Засгийн газар тусгайлан тогтоож болно.

Гурав. Хөрөнгө оруулалтын хэмжээг баталгаажуулах

3.1. Уул уурхай, дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж тухайн жилийн санхүүгийн тайлангаа аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр баталгаажуулахдаа уул уурхай, дэд бүтцийн салбарт оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээ давхар баталгаажуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 288

Улаанбаатар
хот

Жагсаалтад нэмэлт оруулах тухай

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2008 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 83 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт"-д дараахь нэмэлт оруулсугай:

Уул уурхай, олборлолт

В	-	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газарт ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа / стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газарт ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн үндсэн үйлдвэрлэлийн барилгын ажлыг гүйцэтгэж дуусах хүртэлх хугацааг хамарна/
---	---	---

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД**

Д.ЗОРИГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 289

Улаанбаатар
хот

**Зээлийн хөрөнгийн
хуваарилалтын тухай**

"Зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 41 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын 300.0 (гурван зуун) сая ам.долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөс барилгын материалын үйлдвэрлэлд зарцуулахаар төлөвлөж байсан 60.0 (жаран) сая ам.долларыг "Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд 2152 айлын орон сууц, олсн нийтийн барилга байгууламж, сургалт, үйлдвэрлэлийн төвийн хамт барих ажлыг санхүүжүүлэхээр тогтсугай.

2. Дээрх зээлийн хөрөнгөөр орон сууцны ХИҮ хорооллын 8.08 га газар болон орон сууцны ҮП хорооллын 3.6 га газарт орон сууц барих ажлыг зохион байгуулахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд



Х.Баттулга, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч
Г.Мөнхбаяр нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Х.БАТТУЛГА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 294

Улаанбаатар
хот

Хохирогчид нөхөх олговор олгох журам батлах тухай

Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулийн 4.1.1, 5.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хохирогчид нөхөх олговор олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан, нөхөх олговор олгох ажлын явц, дүнг улирал бүр Засгийн газарт танилцуулж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай.

3. Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулийн 4.1.2, 4.1.3, 4.1.4-т заасан нөхөх олговрыг олгоход шаардагдах хөрөнгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад жил бүр тусган санхүүжүүлж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2009 оны 294 дүгээр
тогтоолын хавсралт

ХОХИРОГЧИД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт гарсан нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самууны үеэр амь бие, эрүүл мэнд, эд

хөрөнгөөрөө хохирсон иргэн, цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагч, хуулийн этгээд (цаашид "хохирогч" гэх)-д нөхөх олговор олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Нөхөх олговор олгох үйл ажиллагаанд ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдлыг хангах, хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, хохирогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх зарчим баримтална.

Хоёр. Нөхөх олговор олгох ажлыг зохион байгуулах

2.1. Хохирогчид нөхөх олговор олгох ажлыг Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар байгуулсан ажлын хэсэг (цаашид "Ажлын хэсэг" гэх) зохион байгуулна.

2.2. Ажлын хэсэг нь үйл ажиллагаандаа энэ журам болон Хохирогчид нөхөх олговор олгох тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг удирдлага болгоно.

2.3. Ажлын хэсэг нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.3.1. хохирогчид нөхөх олговор олгох ажлын бэлтгэлийг хангах;

2.3.2. энэ журмын 4.1, 4.2, 4.3-т заасан баримт бичгийг хянаж, нөхөх олговор олгох эсэх тухай шийдвэр гаргах;

2.3.3. энэ журмын 5.1-д заасны дагуу хохирогчид нөхөх олговор олгох үйл ажиллагаатай холбоотой санал, гомдлыг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэх.

2.4. Ажлын хэсэг нь энэ журмын 4.1, 4.2, 4.3-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор хянаж, нөхөх олговор олгох эсэх тухай шийдвэр гаргана. Ажлын хэсгийн дарга зайлшгүй шаардлагатай гэж үзвэл уг хугацааг 7 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

2.5. Ажлын хэсгийн хуралдаанд Ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд таслах эрхтэй оролцоно. Гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.6. Ажлын хэсгийн хуралдааныг Ажлын хэсгийн дарга даргална. Ажлын хэсгийн даргын түр эзгүй үед хуралдааныг Ажлын хэсгийн даргын үүрэг болгосноор аль нэг гишүүн даргална.

2.7. Хуралдаанд хэлэлцүүлэх асуудлыг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга оруулна.

2.8. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлын талаархи шийдвэрийг олонхийн саналаар гаргана.

2.9. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь Ажлын хэсгийн дотоод ажлыг хариуцна. Нарийн бичгийн дарга нь Ажлын хэсгийн хуралдаанаар



хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж, хуралдааны тэмдэглэлийг хөтөлнө. Хуралдааны тэмдэглэлд Ажлын хэсгийн дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Ажлын хэсгийн даргын түр эзгүйд хуралдааны тэмдэглэлд хуралдаан даргалагч гарын үсэг зурна.

2.10. Улсын мөрдөн байцаах газар нь Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуульд заасны дагуу нөхөх олговор олгох хохирогчдын нэрсийн жагсаалт, тэдгээрийг хохирогчоор тогтоосон тогтоол болон хохирогчдын гэмтлийн зэргийг тогтоосон шүүх эмнэлгийн дүгнэлтийг Ажлын хэсэгт ирүүлнэ.

Гурав. Ажлын хэсгийн шийдвэр

3.1. Ажлын хэсэг нь энэ журмын 4.1, 4.2, 4.3-т заасан баримт бичгийг хянан хэлэлцээд хохирогчид нөхөх олговор олгох, эс олгох шийдвэрийн аль нэгийг гаргана.

3.2. Энэ журмын 4.1, 4.2, 4.3-т заасан баримт бичиг хуурамч болох нь тогтоогдвол Ажлын хэсэг уг баримт бичгийг ирүүлсэн этгээдэд буцааж, энэ тухай холбогдох хууль хяналтын байгууллагад мэдэгдэнэ.

3.3. Ажлын хэсгийн шийдвэр нь дүгнэлт хэлбэртэй байх бөгөөд түүнд Ажлын хэсгийн дарга, гишүүд гарын үсэг зурна.

3.4. Дүгнэлтэд дараахь асуудлыг тусгана:

3.4.1. дүгнэлтийг хэзээ, хаана гаргаж байгаа, хурлын дарга болон оролцсон гишүүд, нарийн бичгийн даргын нэр;

3.4.2. нотлох баримтын хууль зүйн болон бодит үндэслэл, түүнийг Ажлын хэсгээс хэрхэн үнэлж байгаа тухай;

3.4.3. дүгнэлтийг гаргахад баримталсан хуулийн нэр, зүйл, хэсэг, заалт.

3.5. Ажлын хэсгийн шийдвэрийг 3 хоногийн дотор Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлнэ. Хууль зүй, дотоод хэргийн сайд шийдвэрийг баталгаажуулна.

3.6. Хууль зүй, дотоод хэргийн сайд Ажлын хэсгийн шийдвэрийг баталгаажуулах үндэслэлгүй гэж үзвэл тухайн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох шийдвэрийн аль нэгийг гаргана.

Дөрөв. Нөхөх олговор авах хүсэлт гаргах

4.1. Хохирогч нь иргэн бол нөхөх олговор авах хүсэлтээ дараахь баримт бичгийн хамтаар Ажлын хэсэгт ирүүлнэ:

4.1.1. иргэний үнэмлэхийн хуулбар;

4.1.2. оршин суугаа сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;

4.1.3. банкин дахь өөрийн харилцах болон хадгаламжийн дансны дугаар;

4.1.4. даатгалын хууль тогтоомжийн дагуу даатгалын нөхөн төлбөр олгосон эсэх тухай даатгалын байгууллагын тодорхойлолт;

4.1.5. хэрэв эрүүл мэндээрээ хохирсон бол гэмтлийн зэргийг тогтоосон шүүх эмнэлгийн дүгнэлт;

4.1.6. хэрэв эд хөрөнгөөрөө хохирсон бол хохирлын хэмжээг тогтоосон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр.

4.2. Хохирогч нь цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын албаны албан хаагч бол түүнийг төлөөлж Цагдаагийн ерөнхий газар буюу Онцгой байдлын ерөнхий газар нөхөх олговор авах хүсэлтийг мөн журмын 4.1.4, 4.1.5-д зааснаас гадна дараахь баримт бичгийн хамт Ажлын хэсэгт ирүүлнэ:

4.2.1. ажлын газрын үнэмлэхийн хуулбар;

4.2.2. тухайн албан хаагчийн 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хашиж байсан албан тушаалынх нь нэг сарын цалингийн тодорхойлолт;

4.2.3. нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр гарсан нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самууны үеэр эрүүл мэндээрээ хохирсонтой холбогдуулан тусламж үзүүлсэн эсэх тухай байгууллагын тодорхойлолт (тусламж үзүүлсэн бол түүний хэмжээ);

4.2.4. банкин дахь байгууллага (Цагдаагийн ерөнхий газар буюу Онцгой байдлын ерөнхий газар)-ын харилцах дансны дугаар.

4.3. Хохирогч нь хуулийн этгээд бол нөхөх олговор авах хүсэлтээ мөн журмын 4.1.4, 4.1.6-д зааснаас гадна дараахь баримт бичгийн хамт Ажлын хэсэгт ирүүлнэ:

4.3.1. улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

4.3.2. банкин дахь байгууллагын харилцах дансны дугаар.

Тав. Нөхөх олговор олгох

5.1. Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулийн 4.1.1-4.1.3-т заасан нөхөх олговрыг энэхүү журмын 3.1-д заасан шийдвэрийг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайд дараахь журмаар олгоно:

5.1.1. амь насаа алдсан иргэний ар гэрт олгох 50.000.000 (тавин сая) төгрөгийг дараахь этгээдэд дор дурдсан дарааллаар:

5.1.1.1. амь насаа алдсан иргэний эхнэр, нөхөр, төрүүлсэн болон үрчилж авсан, түүнийг амь насаа алдсан хойно төрсөн хүүхэд;

5.1.1.2. энэ журмын 5.1.1.1-д заасан этгээд байхгүй, эсхүл тэдгээр нь нөхөх олговор хүлээн авахаас татгалзсан тохиолдолд амь насаа алдсан иргэний төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх;

5.1.1.3. энэ журмын 5.1.1.1, 5.1.1.2-т заасан этгээд байхгүй, эсхүл тэдгээр нь нөхөх олговор хүлээн авахаас татгалзсан тохиолдолд амь



насаа алдсан иргэний өвөг эцэг, эмэг эх, ах, эгч, дүү, ач, ээ;

5.1.2. эрүүл мэндээрээ хохирсон цагдаа болон онцгой байдлын албан хаагчид шүүх эмнэлгийн шинжилгээгээр тогтоогдсон гэмтлийн зэргийг нь харгалзан 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хашиж байсан албан тушаалынх нь нэг сарын цалинг Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулийн 4.1.2-т заасан хэмжээгээр өсгөж.

Тайлбар: нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр гарсан нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самууны үеэр эрүүл мэндээрээ хохирсонтой нь холбогдуулан цагдаа болон онцгой байдлын албан хаагчид харьяалсан байгууллагаас нь тусламж үзүүлсэн тохиолдолд уг тусламжийг нөхөх олговроос хасч тооцно;

5.1.3. эрүүл мэндээрээ хохирсон иргэнд шүүх эмнэлгийн шинжилгээгээр тогтоогдсон гэмтлийн зэргийг нь харгалзан 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулийн 4.1.3-т заасан хэмжээгээр өсгөж.

5.2. Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулийн 4.1.4-т заасан нөхөх олговрыг шүүхийн шийдвэр, түүний үндсэн дээр бичигдсэн гүйцэтгэх хуудсыг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон энэхүү журамд заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар олгоно.

5.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь энэхүү журмын 5.2-т заасны дагуу олгосон нөхөх олговортой холбоотой ажлын тайлангаа тухай бүр Ажлын хэсэгт ирүүлнэ.

5.4. Нөхөх олговрыг хохирогчийн банкин дахь харилцах, хадгаламжийн дансанд шилжүүлнэ.

Зургаа. Нөхөх олговрыг буруутай этгээдээр буцаан төлүүлэх

6.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулийн 7.1-д заасан төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу хариуцан зохион байгуулна.

Долоо. Бусад зүйл

7.1. Хуурамч баримт бичиг бүрдүүлж, эсхүл худал мэдүүлж энэхүү журамд заасан нөхөх олговрыг авсан гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэж, хохирлыг буцаан төлүүлнэ.

7.2. Хохирогчид нөхөх олговор олгох үйл ажиллагаатай холбогдон маргаан үүссэн тохиолдолд уг маргааныг хянан шийдвэрлэх хүртэлх хугацаанд тухайн хохирогчтой холбоотой нөхөх олговор олгох ажлыг түдгэлзүүлнэ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 295

Улаанбаатар
хот

Эрчим хүчний салбарын 2009-2010 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний үйлдвэр, компаниудын 2009-2010 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд үндсэн болон туслах тоноглолын засварыг графикт хугацаанд нь чанартай хийж, техник зохион байгуулалт болон нүүрс нөөцлөх ажлыг эрчимжүүлэн 2009 оны 10 дугаар сарын 15-ны дотор бүрэн дуусгахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Төрийн өмчийн хороо (Д.Сугар) -нд даалгасугай.

2. "Даланзадгадын дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компани, "Багануурын дулааны станц" төрийн өмчит хувьцаат компани, "Говь-Алтай эрчим хүч" төрийн өмчит улсын үйлдвэрийн газар, "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компаниудын урсгал зардал болон их засварт шаардагдах 1 дүгээр хавсралтад заасан 1,318.3 (нэг тэрбум гурван зуун арван найман сая гурван зуун мянган) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

3. Сэлэнгэ аймгийн "Сэлэнгэ энерго" орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болон Дархан-Уул аймгийн Шарын гол сумын "Дулаан Шарын гол" орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын өвөлжилтийн бэлтгэлд шаардагдах 2 дугаар хавсралтад заасан засварын зардлыг тооцоог нь хянасны үндсэн дээр төсвийн зээл олгох, төрийн болон орон нутгийн өмч хамтарсан аж ахуйн нэгж байгуулах зэрэг арга замаар шийдвэрлэхийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Сангийн сайд С.Баярцогт, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд үүрэг болгосугай.

4. "Увс дулааны станц" ХХК, Ховд аймгийн "Бадамлах дөл" ХХК-уудын өвөлжилтийн бэлтгэлд шаардагдах 3 дугаар хавсралтад заасан



засварын зардлыг тооцоог нь хянасны үндсэн дээр төсвийн зээл олгох, төрийн болон хувийн өмч хамтарсан аж ахуйн нэгж байгуулах, Засгийн газрын нөөц сангаас санхүүжилт олгох зэрэг арга замаар шийдвэрлэхийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Сангийн сайд С.Баярцогт, Увс аймгийн Засаг дарга Э.Цасчихэр, Ховд аймгийн Засаг дарга Г.Нямдаваа, Төрийн өмчийн хороо (Д.Сугар) нарт даалгасугай.

5. Төрийн өмчит дулааны цахилгаан станцуудын 2009-2010 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд "Нүүрсний аюулгүйн нөөц" бүрдүүлэхэд шаардагдах 5,3 (таван тэрбум гурван зуун сая) тэрбум төгрөгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэхийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай.

6. "Говь-Алтай эрчим хүч" төрийн өмчит улсын үйлдвэрийн газар, "Улиастай эрчим хүч" төрийн өмчит улсын үйлдвэрийн газар, "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компани, "Баруун бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компани, "Даланзадгадын дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компани, "Багануурын дулааны станц" төрийн өмчит хувьцаат компани, "Налайхын дулааны станц" төрийн өмчит хувьцаат компанид олгох шаардлагатай байгаа 4 дүгээр хавсралтад заасан татаасын тооцоог хянан 2010 оны улсын төсөвт тусгах арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Сангийн сайд С.Баярцогт нарт тус тус даалгасугай.

7. "Даланзадгадын дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн өргөтгөлийн ажилд шаардагдах хөрөнгийн асуудлыг судалж орон нутгийн өмчийн оролцоотойгоор шийдвэрлэх арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Төрийн өмчийн хороо (Д.Сугар), Өмнөговь аймгийн Засаг дарга Б.Бадраа нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД**

Д.ЗОРИГТ



**Засгийн газрын 2009 оны 295 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт**

**2009-2010 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ
ИХ ЗАСВАРЫН АЖИЛД ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГӨ**

№	Үйлдвэр, компаниуд	Хийгдэх гол ажлууд	Шаардагдах зардал, (сая.төг)
1	"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компани	Үйл ажиллагааны зардал	198
2	"Даланзадгадын дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компани	Зуух № 1, 2-ын их засвар Турбин генераторын их засвар, регуляторуудыг цахилгаан регулятороор сольж 4 ком-ыг суурилуулах Дулаан түгээх төвүүдэд хийгдэх их засвар Туслах тоног төхөөрөмжүүдийн засвар шинэчлэл	511.3
3	"Багануурын дулааны станц" төрийн өмчит хувьцаат компани	Циклоны үнсний гадна бункерийн үнс буулгалтын системийг засварлах Зуух № 5, 6-ын утаа сорогчийн их засвар ҮТ-3-ын салбар шугамын өөрчлөлт Нүүрс шидэгч 2 ком шинээр суурилуулах болон туслах тоног төхөөрөмжийн засварын ажил	109
4	"Говь-Алтай эрчим хүч" төрийн өмчит улсын үйлдвэрийн газар	500 кВт 2 ширхэг дизель генератор худалдан авч суурилуулах	500.0
Нийт			1,318.3



**Засгийн газрын 2009 оны 295 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт**

**ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН 2009-2010 ОНЫ
ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ ИХ ЗАСВАРЫН
АЖИЛД ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГӨ**

№	Үйлдвэр, компаниуд	Хийгдэх гол ажлууд	Шаардагдах зардал, (сая.төг)
1	Сэлэнгэ аймгийн "Сэлэнгэ энерго" орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	3 зуухны халах гадаргуу, ул ширэм солих, өрлөг дулаалгын ажил болон туслах тоног төхөөрөмжийн шинэчлэл	210.0
2	"Дулаан Шарын гол" орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	Халаалтын зуух, шугам тоноглолын засвар	94.3
Нийт			304.3

**Засгийн газрын 2009 оны 295 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт**

**"УВС ДУЛААНЫ СТАНЦ" ХХК БОЛОН ХОВД АЙМГИЙН
"БАДАМЛАХ ДӨЛ" ХХК-ИЙН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ
ИХ ЗАСВАРЫН АЖИЛД ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГӨ**

№	Үйлдвэр, компаниуд	Хийгдэх гол ажлууд	Шаардагдах зардал, (сая.төг)
1	Ховд аймгийн "Бадамлах дөл" ХХК	Зуух-4-ийн галын хотлын экрэн солих, ул ширэм бүрэн шинэчлэх, ПМЗ солих	300.0
2	"Увс дулааны станц" ХХК	Циклоны үнсний гадна бункерийн үнс буулгалтын системийг засварлах Зуух №5, 6-гийн утаа сорогчийн их засвар ҮТ-3-ын салбар шугамын өөрчлөлт Нүүрс шидэгч 2 ком шинээр суурилуулах болон туслах тоног төхөөрөмжийн засварын ажил	300.0
Нийт			600.0

**Засгийн газрын 2009 оны 295 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт**

2010 ОНЫ УЛСЫН ТӨСӨВТ ТУСГАХ ТАТААС

№	Үйлдвэр, компанийн нэр	Татаас хэмжээ (сая.төг)
1	"Даланзадгадын дулааны цахилгаан станц" хувьцаат компани	1800.0
2	"Дорнод бүсийн эрчим хүчний систем" хувьцаат компани	1200.0
3	"Баруун бүсийн эрчим хүчний систем" хувьцаат компани	5101.3
4	"Багануурын дулааны станц" хувьцаат компани	1120.8
5	"Налайхын дулааны станц" хувьцаат компани	941.0
6	Говь-Алтайн эрчим хүчний үйлдвэр	8122.7
7	Завханы эрчим хүчний үйлдвэр	8480.0
	Нийт дүн	26,765.8

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 296

Улаанбаатар
хот

**Мал өвөлжилтийн бэлтгэл хангахтай
холбогдуулан авах нэмэлт арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гантай болон гандуу байгаа аймгуудын улсын нөөцийн цэг, салбарт нэмж байршуулах өвс, тэжээлийн хэмжээ болон түүнийг тээвэрлэх зардлыг 1 дүгээр хавсралт ёсоор баталж, түүнд шаардагдах 393.8 (гурван зуун ерэн гурван сая найман зуун мянган) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

2. Бусад аймаг, сумын нутагт отроор өвөлжиж байгаа малчдад үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн бусад нэмэлт үйлчилгээнд зориулан Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газарт 25.0 (хорин таван) сая төгрөг, Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газарт 30.0 (гучин) сая төгрөг, Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газарт 20.0 (хорин)

сая төгрөг, Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газарт 30.0 (гучин) сая төгрөг, Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газарт 60.0 (жаран) сая төгрөг, Ховд аймгийн Засаг даргын Тамгын газарт 25.0 (хорин таван) сая төгрөг, Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газарт 18.0 (арван найман) сая төгрөг, нийт 208.0 (хоёр зуун найман сая) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

3. Аймаг, сум дундын отрын нөөц газарт шинээр гаргах болон сэргээн засварлах хугацааг тоог 2 дугаар хэвсрэлт ёсоор баталж, түүнд шаардагдах 149.4 (нэг зуун дөчин есөн сая дөрвөн зуун мянган) сая төгрөгийг 2009 оны төсвийн багцаасаа зохицуулан санхүүжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд зөвшөөрсүгэй.

4. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод даалгасугай:

а) Дундговь аймгийн Говь-Угтаал, Говь-Алтай аймгийн Төгрөг, Эрдэнэ, Баян-Уул, Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Номгон, Увс аймгийн Бөхмөрөн суманд улсын нөөцийн түр цэг байгуулан өвс, тэжээл татан байршуулж, түүнийг хадгалах, хамгаалахтай холбогдон гарах зардлыг холбогдох аймгийн Засаг даргатай хамтран орон нутагт нь зохицуулан шийдвэрлэх арга хэмжээ авсугай;

б) энэ тогтоолын 1 дүгээр хэвсрэлтэд заасан улсын нөөцийн цэг, салбар болон шинээр байгуулах түр цэгт өвс, тэжээл байршуулах ажлыг зам, даваа цасанд хаагдахаас өмнө зохион байгуулан, өвс, тэжээлийг улсын нөөцөд бэлтгэсэн үнээр нь малчид, иргэдэд худалдан борлуулах арга хэмжээ авсугай.

5. Гантай болон гандуу байгаа аймгууд, холбогдох яамнаас ирүүлсэн хүсэлтийг харгалзан тусгай хамгаалалттай болон хилийн зурвас газарт мал өвөлжүүлж, хаваржуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.

6. Говийн бүсийн аймгуудад цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээг жил бүрийн 3 дугаар сарын 15-наас 10 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхэд үүрэг болгосугай.

7. Мал өвөлжүүлж, хаваржуулах талаар дараахь арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд даалгасугай:



а) бэлчээрийн даац хүрэлцээгүй байгаа аймгуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу бэлчээрийн гарц сайтай аймаг, сумд болон аймаг дундын отрын бүс нутаг, тусгай хамгаалалттай газар, хилийн зурваст мал өвөлжүүлж, хаваржуулах төлөвлөгөө, зураглалыг холбогдох яам, Засгийн газрын агентлаг, аймгийн Засаг дарга нартай хамтран гаргаж, зохион байгуулан хяналт тавьж ажилласугай;

б) мал, мах бэлтгэх төвлөрсөн болон хээрийн цэг ажиллуулж, чанар, стандартад нийцсэн мах бэлтгэх, махыг дотоод болон гадаад зах зээлд борлуулах аж ахуйн нэгж, иргэдийг дэмжих арга хэмжээг аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулсугай;

в) гадаад орнуудтай мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах гэрээ байгуулах бэлтгэлийг холбогдох яам, Засгийн газрын агентлагийн удирдлагатай хамтран хэрэгжүүлсүгэй.

8. Дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай:

а) өөрийн болон бусад аймгийн нутаг дэвсгэрт мал өвөлжүүлж, хаваржуулах арга хэмжээг холбогдох аймаг, сумын удирдлагатай гэрээний үндсэн дээр зохион байгуулж, малчид олноор нүүн нутаглаж байгаа газарт отрын штаб байгуулж ажиллуулан, малчдад хүн, мал эмнэлэг, төрийн бусад үйлчилгээг шуурхай хүргэх болон цаг агаарын сэрэмжлүүлэг, мэдээллээр тухай бүр хангаж ажилласугай;

б) өвс, тэжээлийн хүрэлцээтэй аймаг болон орон нутгийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг нэмж бүрдүүлэх, өвс, тэжээлийг малчдад худалдан борлуулах арга хэмжээг авсугай.

9. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон биелэлтийг сар бүр Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Т.БАДАМЖУНАЙ

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

Засгийн газрын 2009 оны 296 дугаар
 тогтоолын 1 дүгээр хавсралт

**ГАНТАЙ БОЛОН ГАНДУУ БАЙГАА АЙМГУУДЫН УЛСЫН НӨӨЦИЙН ЦЭГ, САЛБАРТ
 НЭМЖ БАЙРШУУЛАХ ӨВС, ТЭЖЭЭЛИЙН ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ТҮҮНИЙГ
 ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН ХУВААРЬ**

№	Хаанаас	Хаана байршуулах	Нэр төрөл	Тоо хэмжээ (тн)	Тээвэрлэх зай (км)	Нэг тн/км-ийн үнэ	Шаардагдах тээврийн зардал (мян. төг)
1		Баянхонгор аймгийн төвийн өвс, тэжээлийн улсын нөөцийн салбарт	Өвс	400	650	210	54,600.0
2	Улаанбаатар хот дахь улсын нөөцийн салбараас	Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум дахь нөөцийн тур цэгт	Тэжээл	200	650	210	27,300.0
3		Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум дахь нөөцийн тур цэгт	Өвс	100	900	210	18,900.0
4		Говь-Алтай аймгийн Баян-Уул сум дахь нөөцийн тур цэгт	Тэжээл	100	900	210	25,620.0
5		Говь-Алтай аймгийн Төгрөг сум, Борбулаг дахь нөөцийн тур цэгт	Өвс	100	1220	210	25,620.0
6		Дундговь аймгийн Говь-Угтаал сум дахь нөөцийн тур цэгт	Тэжээл	200	1100	210	46,200.0
			Тэжээл	100	1100	210	23,100.0
			Өвс	200	1230	210	51,660.0
			Тэжээл	100	1230	210	25,830.0
			Өвс	100	338	210	7,098.0
			Тэжээл	50	338	210	3,549.0



7	Өмнөговь аймгийн төвийн өвс, тэжээлийн улсын нөөцийн салбарт	Өвс	200	610	210	25,620.0
		Тэжээл	100	610	210	12,810.0
8	Өмнөговь аймгийн Мандал-Овоо сум дахь өвс, тэжээлийн улсын нөөцийн түр цэгт	Өвс	50	477	210	5,008.5
		Тэжээл	50	477	210	5,008.5
9	Өмнөговь аймгийн Номгон сум дахь нөөцийн түр цэгт	Өвс	40	763	210	6,409.2
		Тэжээл	40	763	210	6,409.2
10	Увс аймгийн Бөхмөрөн сум дахь нөөцийн түр цэгт	Өвс	50	195	210	2,047.5
		Тэжээл	50	195	210	2,047.5
Бүгд		Өвс	1440			243,163.0
		Тэжээл	890			150,574.0
Нийт зардал			2,330.0			393,737.40

Засгийн газрын 2009 оны 296 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

АЙМАГ, СУМ ДУНДЫН ОТРЫН НӨӨЦ ГАЗАРТ ШИНЭЭР ГАРГАХ БОЛОН СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ХУДГИЙН ТОО, ТҮҮНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ХУВААРЬ

№	Аймаг сумын нэр	Уст цэг гаргах газар, байршил	Шинээр гаргах, засварлах уст цэгийн төрөл	Шаардагдах зардал (мян.төг)
1	Баянхонгор аймгийн Баянлиг сум	Өвөрцэвчлал	Гүн өрмийн худаг шинээр гаргах	14,000.0
2	Баянхонгор аймгийн Шинэжинст сум	Ганц мөнд	Худаг сэргээн засварлах /мотор, насос шинээр таах/	2,000.0

3	Баянхонгор аймгийн Шинэжинст сум	Харбоом	Худаг сэргээн засварлах /мотор, насос шинээр тавих/	3,000.0
4	Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум	Идрэнгийн нурууны өвөр хэсэгт	Шинээр гар худаг 3-ыг гаргах	2,400.0
5	Говь-Алтай аймгийн Хөхморет сум	Ясан-Овоо	Гүн өрмийн худаг шинээр гаргах	13,000.0
6	Говь-Алтай аймгийн Хөхморет сум	Хонгортолгой	Гүн өрмийн худаг шинээр гаргах	13,000.0
7	Говь-Алтай аймгийн Жаргалант сум	Тээлт	Гүн өрмийн худаг шинээр гаргах	14,000.0
8	Дундговь аймгийн Өлзийт сум	Үнэгт	Гүн өрмийн худаг шинээр гаргах	14,000.0
9	Дундговь аймгийн Сайхан-Овоо сум	Дундын нуруу	Хайгуул хийж гүн өрмийн худаг шинээр гаргах	16,000.0
10	Өмнөговь аймгийн Мандал-Овоо сум	Мандал холбоо навтгар	Гүн өрмийн худаг шинээр гаргах	14,000.0
11	Өмнөговь аймгийн Манлай сум	Амгалант	Гүн өрмийн худаг шинээр гаргах	14,000.0
12	Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум	Доод хаалга	Гүн өрмийн худаг шинээр гаргах	14,000.0
13	Баян-Өлгий аймгийн Улаанхус сум	Орготын эзэн	Гүн өрмийн худаг шинээр гаргах	13,000.0
14	Баян-Өлгий аймгийн Бугат сум	Улаантосгон	Худаг сэргээн засварлах /мотор шинээр тавих/	3,000.0
Бүгд				149,400.0

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2009 оны 10 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ, ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн Хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д заасныг удирдлага болгон **Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:**

1. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1, 2-т заасан цэргийн жинхэнэ албан хаагчийн насны дээд хязгаарт Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2, 3-т заасан цэргийн албан хаагчид хамаарна.

2. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4, 5-д заасан генерал, комиссар, офицер, ахлагч, байлдагчийн цэргийн алба хаах насны дээд хязгаарыг тогтоох, алба хаах хугацааг сунгах асуудлыг эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт багтаан шийдвэрлэхэд Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д заасан зохицуулалт саад болохгүй.

3. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1-д заасан **"цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй"** гэдгийг тухайн албыг хаах насны дээд хязгаарт хүрснээс бусад тохиолдолд цэргийн албан хаагч өөрийн санаачилгаар тэтгэвэр тогтоолгох боломжтой гэж ойлгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР


ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Ц.АМАРСАЙХАН

Хяаг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци,
Улаанбаатар-12, Төрийн ордон 128 тоот
И-мэйл: turin_medecelele@parliament.mn
Утас: 262420, 329612
Хэвлэлийн хуудас 1,75

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.
Утас 329487